



ТӨВ АЙМАГ

**2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАРАА,
АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУДАЛДАН
АВАЛТЫН ТАЙЛАН**

Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаал “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам маягт 2-9”

2019.12.31

Агуулга

Ерөнхий зүйл

Нэг. Төв аймгийн 2019 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:

- 1.1. Төв аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр тоо баримт, биелэлтийн хувиар.
- 1.2. 2019 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авах ажиллагааны талаарх тайлбар, үндэслэл болон хэрэгжилтийн мэдээлэл.
- 1.3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэгдээгүй болон дугуу биелсэн ажлын шалтгаан, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаа.
- 1.4. Тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд хийсэн эсэх тухай.
- 1.5. Худалдан авах ажиллагааны явцад гарсан зөрчил, түүнийг хэрхэн засаж залруулсан тухай.
- 1.6. Худалдан авах ажиллагааны талаар гарсан гомдол, түүнийг шийдвэрлэсэн тухай.
- 1.7. Чанар стандартын шаардлага хангасан дотоодын бараа худалдан авсан мөнгөн дүн, нийлүүлэгчийн нэр, гэрээний хэрэгжилтийн байдал.

Хоёр. Худалдан авах ажиллагааны цахим системийг ашигласан талаар

- 2.1. Худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан тендер шалгаруулалтын тоо, хувь болон систем ашиглалтын байдал.
- 2.2. Ерөнхий гэрээ байгуулах журмын дагуу цахим дэлгүүрийн ашиглалт болон тухайн жилд худалдан авсан бараа, үйлчилгээний тоо, мөнгөн дүн, гэрээний хэрэгжилтийн байдал.

Гурав. Харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны талаар.

- 3.1. Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын тоо, тэдгээрийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн талаар ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагааг зааварчилгаа, аргачлалаар хангасан байдал болон түүнд хяналт тавьж ажилласан байдал.

3.2. Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ өгсөн тухай зөвлөм, дүгнэлт болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.

Дөрөв. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн талаарх дүгнэлт, санал

4.1. Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн үр дүнгийн талаарх өөрийн үнэлгээ, дүгнэлт.

4.2. Гэрээний хэрэгжилтэд хэрхэн хяналт тавьж ажилласан байдал.

4.3. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг цаашид улам үр дүнтэй болгох санал, зөвлөмж, хүсэлт.

Ерөнхий зүйл:

Монгол Улсын Төсвийн тухай хууль, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, түүнийг даган гарсан журам эрх зүйн актууд болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн “Аймгийн 2019 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоол, 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 13 дугаар хуралдааны 02 дугаар тогтоол, 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 15 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолыг үндэслэн 2019 онд аймагт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийг батлуулж ажилласан.

Дээрхи тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/715, 2019 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/391, 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/644 дүгээр захирамжаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон нэмэлт төлөвлөгөөг батлаж, аймгийн Засаг даргын 2018 оны А/736, 2019 оны А/391, А/644 дүгээр захирамжаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаж батлагдсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэх ажилд хяналт тавьж ажиллах үүрэг бүхий захиалагч байгууллагуудыг томилон ажиллуулсан.

Худалдан авах ажиллагааны тайлан, мэдээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйл, Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаал “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
[2019.12.31]



Ж. БАТЖАРГАЛ

Нэг. Аймгийн 2019 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт

1.1. Төв аймгийн 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт санхүүжилтийн эх үүсвэр бүрээр тоо баримт, биелэлтийн хувиар:

2019 онд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авахаар тусгагдсан нийт ажлын ерөнхий мэдээлэл:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн “Аймгийн 2019 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2018 оны А/715 дугаар захирамжаар 10,346.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр 8,037.0 сая төгрөгийн 65 төсөл арга хэмжээг тусган баталсан.
2. Аймгийн ИТХурлын 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн “Тогтоолын зарим заалтад өөрчлөлт оруулах, жагсаалт батлах тухай” 13 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2019 оны А/391 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтаар зарим төсөл, арга хэмжээний нэр, зарцуулах санхүүжилтийн дүн, худалдан авах ажиллагаа, тендер шалгаруулалтын төрөл зэргийг өөрчлөн 585.0 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээг тусган 2019 онд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны нэмэлт төлөвлөгөөг батлаж тус захирамжийн хоёрдугаар хавсралтаар захиалагч байгууллагыг тус бүр томилсон.
3. Аймгийн ИТХурлын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 15 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоол “Тогтоолын зарим заалтад өөрчлөлт оруулах тухай”-ын дагуу аймгийн Засаг даргын 2019 оны А/644 дүгээр захирамжаар төсөл, арга хэмжээний нэр, төсөвт өртөгт өөрчлөлт оруулж 49.7 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг батлаж захиалагч байгууллагыг холбогдох хууль, журмыг үндэслэн байгуулсан.

Дээрхи тогтоол, захирамжийн шийдвэрээр 2019 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 72 төсөл, арга хэмжээнд 10,321.7 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан бөгөөд үүнээс 2018 онд тендер шалгаруулалт зохион байгуулагдсан болон 2019 онд гэрээ шууд байгуулж хэрэгжүүлэх 1,417.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ажлын үлдэгдэл санхүүжилтэд 907.1 сая төгрөгийг олгохоор төлөвлөгдөж батлагдсан.

Төв аймгийн Засаг даргад 2019 онд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх (ЗГХЭГ, ЗТХЯ, ЭМЯ, БСШУСЯ)-ээр, эрх шилжүүлсэн 32,772.2 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг аймагт зохион байгуулахаар, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 56 төсөл, арга хэмжээний 8,903.8 сая төгрөгийн **нийт 41,676.0 сая төгрөгийн 72 ажилд тендер шалгаруулалтыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт төвлөрүүлэн зохион байгуулахаар шийдвэрлэж** ажилласан.

Нийт худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг олон нийтэд зарлан мэдээлсэн байдал:

”Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах” тухай хуулийн 48.5-д заасны дагуу худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг хуулийн хугацаанд багтаан 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn вэб сайт, Төв аймгийн www.tov.gov.mn сайт, www.khural.mn сайт, www.umch.to.gov.mn, www.shilendans.gov.mn сайт, өдөр тутмын “Монголын үнэн” сонины 2019 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн 04 дүгээр хэвлэлд нийтлэн олон нийтэд мэдээллэж ажилсан.

Аймагт хэрэгжсэн худалдан авах ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр: Төв аймагт улс, аймгийн төсвийн хөрөнгө болон орон нутгийн хөгжлийн сан, бусад төсвийн эх үүсвэрүүдээр нийтдээ 41,676.0 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй 72 төсөл, арга хэмжээний худалдан авалт хийгдэхээр төлөвлөгдсөн байна. **Аймагт хэрэгжиж байгаа ажлын худалдан авах ажиллагааны явц тайлант оны эхний хагас жилд 99 хувьтай байна.**

Хүснэгт-1: Аймгийн ОНӨГХАААлбанд зохион байгуулагдах нийт ажлууд, санхүүжилтийн эх үүсвэрээр

д/д	Санхүүжилтийн эх үүсвэр	Хэрэгжүүлэх ажлын тоо	Төсөвт өртөг (сая,төг)	2019 онд олгох санхүүжилт (сая,төг)
1	Улсын төсвийн хөрөнгөөр	16	32,772.2	19,646.1
2	Урсгал төсвийн хөрөнгөөр	1	1,786.6	1,786.6
4	Аймгийн төсвийн шилжих үлдэгдэл	15	2,548.2	2,273.2
5	Аймгийн ОНХөгжлийн Сан	22	3,689.9	2,166.3
6	Аймгийн ОНЗамын Сан	7	209.4	209.4

7	Аймгийн БХНССан	11	669.7	669.7
НИЙТ ДҮН		72	41,676.0	26,751.3

Хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилтийн байдал, санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар:

- Аймгийн Засаг даргад 2019 онд Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 388 дугаар тогтоолоор БСШУСЯам, ЗГХЭГазар, ЗТХЯам, ЭМЯам зэрэг дээд шатны 4 яамнаас 32,772.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2019 онд 19,646.1 сая төгрөгийн санхүүжилт олгох 16 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах шийдвэрийг гаргаж, эрх шилжүүлсэн ажлуудын худалдан авах ажиллагааг 100 хувь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байна.

2. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар

- Аймгийн төсвийн шилжих үлдэгдэл: 2,548.2 сая төгрөгийн 15 төсөл хөтөлбөр, арга хэмжээнд тендер шалгаруулалт зохион байгуулахаас 2,526.3 сая төгрөгийн 14 төсөл арга хэмжээний тендерийг зохион байгуулж 95 хувьтай ХАА-г зохион байгуулсан байна.
- Аймгийн ОНХөгжлийн сан: 3,689.9 сая төгрөгийн 22 ажилд тендер шалгаруулалт зохион байгуулахаас 18 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан мөн ОНХСангаас хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн 4 төсөл, арга хэмжээнд аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон захиалагч байгууллага болон аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГазар гэрээ шууд байгуулж нийт 22 төсөл, арга хэмжээг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.
- Аймгийн Орон нутгийн замын сан: 209.4 сая төгрөгийн 7 ажлын ХАА-г зохион байгуулж хэрэгжүүлэхээс 166.3 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээнд цахим тендер шалгаруулалтыг зохион байгуулсан, захиалагч байгууллагын шийдвэрээр 1 төсөл, арга хэмжээнд гэрээ шууд байгуулж, 1 төсөл арга хэмжээнд ТБОНӨХБАҮХАТХуулийн 34.1.5-т заасны дагуу хэрэгжүүлэх ажил тул гэрээ шууд байгуулах шийдвэрийг гаргаж тус сангийн хөрөнгө оруулалтын ажлыг 100 хувь зохион байгуулсан.

- Аймгийн Байгаль Хамгаалах сангийн хөрөнгөөр 669.7 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас 509.0 сая төгрөгийн 6 ажилд тендер зарлаж ажилласан бөгөөд аймгийн Засаг даргын 2018 оны А/736 дугаар захирамжаар томилогдсон захиалагч байгууллага болох аймгийн ХХААГазраас аймгийн Засаг даргын 2019 оны А/209, А/234 дүгээр захирамжаар 128.3 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг сумдад эрх шилжүүлж хэрэгжүүлэхээр, аймгийн БОАЖГазар 1 төсөл, арга хэмжээг мэргэжлийн байгууллагаар шууд гүйцэтгүүлэхээр, аймгийн БЗОСК ОНӨААТҮГазар 1 төсөл, арга хэмжээнд гэрээ шууд байгуулж ажиллан хэрэгжилтийг 100 хувьтай зохион байгуулсан.

2018 онд тендер шалгаруулалт нь зохион байгуулагдсан, 2019 онд шууд худалдан авах нийт 1,417.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 төсөл, арга хэмжээний санхүүжилтэнд 877.6 сая төгрөг олгох ажлын худалдан авах ажиллагаа 100 хувьтай хэрэгжсэн байна.

Хүснэгт-2: ХАА-гаа зохион байгуулагдахгүй нийт ажлууд, санхүүжилтийн эх үүсвэрээр

д/д	Тендер зарлагдахгүй төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр	Баталсан шийдвэр	Санхүүжилт олгох хэлбэр	Төсөл, арга хэмжээний тоо	Нийт төсөвт өртөг	2019 онд олгох санхүүжилт	
1	Аймгийн Он Хөгжлийн сан	ОН		5	678.6	454.9	
2	Аймгийн Замын сан	ОН	Аймгийн ИТХ-н 2018 оны 2, 2019 оны 2 дугаар тогтоол	2018 онд тендер зарласан болон төсөл, хөтөлбөрийн орон нутгийн оролцоо, шууд худалдан авалт	6	315.1	257.2
3	Аймгийн БХСан			3	99.0	49.0	
4	Аймгийн төсвийн шилжих үлдэгдэл			2	326.0	146.0	
НИЙТ ДҮН				16	1,418.7	907.1	

1.2 2019 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авах ажиллагааны талаарх тайлбар, үндэслэл болон хэрэгжилтийн мэдээлэл:

2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 8 төсөл, хөтөлбөрт тендер шалгаруулалтыг зохион явуулсан. Үүнээс:

- Аймгийн Засаг даргын нөөц сангаас 2019-2020 оны нөөцийн өвс худалдан авахад 30.0 сая төгрөгийг төсөвлөж тендер шалгаруулалтыг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 100 хувь зохион байгуулж гэрээг Голден лайн ХХК-тай байгуулж ажилласан.

- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 88 дугаар тогтоол, 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 99 дүгээр тогтоолоор “Алтанбулаг суманд 75 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажил” хэрэгжүүлэх 758.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсний дагуу аймгийн БЗОСК ОНӨААТҮГазрын захиалагаар цахим тендерийг зарлаж гүйцэтгэгчээр Халзанхайрхан ХХК шалгарч гэрээг 2019-2020 онд гүйцэтгэхээр ажиллаж байна.
- Аймгийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газраас ОНӨГазарт эрх шилжиж ирсэн 70.9 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээнд цахим тендер шалгаруулалтыг зохион байгуулж үнэлгээний хорооны шийдвэрээр гэрээ байгуулж ажиллах шийдвэрийг хүргүүлж ажилласан.
- Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2019 онд шаардагдах шатахууны тендерийг зохион байгуулуулах эрхийг ОНӨГазарт шилжүүлж цахим тендер шалгаруулалтыг зохион байгуулж Магнай трейд ХХК-тай гэрээ байгуулах дүгнэлтийг хүргүүлж ажилласан.
- Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 38.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээний эрхийг мөн ОНӨГазарт шилжүүлж үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Мандухай цэцэн ХХК, Магнай трейд ХХК-тай тус тус гэрээг байгуулж хэрэгжүүлэн ажилласан байна.

Аймгийн түвшинд зохион явуулсан ХАА-ны тендер шалгаруулалтын журам, арга:

д/д	Тендер зохион байгуулсан арга	Ажлын тоо
ХАА-г зохион байгуулах ажлын хувьд		
1	Нээлттэй тендер шалгаруулалт	45
2	Хязгаарлагдмал тендер шалгаруулалт	-
3	ТШОЖ-харьцуулалтын арга	30
4	Зөвлөх үйлчилгээ	3
5	Гэрээ шууд байгуулсан	9
Бүлгийн дүн		87
ХАА зохион байгуулахгүй ажлын хувьд		
1	ШХА-шууд худалдан авах	9
2	ШС-шууд санхүүжилт олгох	
Бүлгийн дүн		9
НИЙТ ДҮН		96

1.3 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэгдээгүй болон дутуу биелсэн ажлын шалтгаан, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаа:

2019 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлуудаас дараах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй байна. Үүнд:


1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 15 дугаар хуралдааны 1 дүгээр тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/644 дүгээр захирамжаар Борнуур сумын Эрүүл мэндийн төвийн автомашиныг шинэчлэхэд 21.7 сая төгрөгийн төсөв өртөгтэй ажлын үнэлгээний хорооны гишүүд ирц бүрдэж хуралдаагүй тул тендер шалгаруулалтыг 2020 оны 1 дүгээр сарын 03-нд зарлаж ажилласан.

1.4 Тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд хийсэн эсэх тухай:

Тайлант онд нийт 73 төсөл, арга хэмжээнд тендер зарлаж үнэлгээг тендер хүчинтэй байх хугацаанд үнэлж, 2 төсөл, арга хэмжээний тендерийн хүчинтэй хугацааг сунгах хүсэлтэй Сангийн яаманд хүргүүлж ажилласан. Үнэлгээний хорооноос гарсан шийдвэр, дүгнэлтийг Захиалагч байгууллагад хугацаанд нь гэрээ байгуулах эрхийг хүргүүлсэн байна.

Тендерийн үнэлгээний дундаж хугацаа: Тендер шалгаруулалтыг тендер нээснээс хойш хүчинтэй хугацаа хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт зааснаар 30 хоног байх бөгөөд аймгийн хэмжээнд тендерийг үнэлэх дундаж хугацаа 20 хоног байна.

График: Аймгийн худалдан авах ажиллагааны газарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн тендерийн дундаж хугацаа



1.5. Худалдан авах ажиллагааны явцад гарсан зөрчил, түүнийг хэрхэн засаж залруулсан тухай:

Тендер шалгаруулалтыг зохион явуулах явцад тендерийн баримт бичигт 2-3 удаа тодруулга хийх зэрэг зөрчлүүд гарч байсан бөгөөд түүнийг тухай бүрд нь залруулж, уг жишээг нарийн бичгийн дарга нарын техникийн зөвлөгөөн дээр ярилцан, зөвлөгөө өгч ажилласан.

1.6. Худалдан авах ажиллагааны талаар гарсан гомдол, түүнийг шийдвэрлэсэн тухай:

Тайлан онд төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн 10 төсөл, арга хэмжээнд 19 гомдол мөн харьяа байгууллагын хэмжээнд 3 төсөл, арга хэмжээнд 3 гомдол тус тус бүртгэгдсэн байна. Үүнд:

д/д	Гомдол гарсан төсөл, арга хэмжээний нэр	Гомдлын бүртгэл				Гомдол шийдвэрлэлт	
		Захиалагчид	ШӨХТГ	СЯаманд	Шүүхэд	Үндэслэлгүй	Үндэслэлтэй
1	Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах	1	-	4	-	3	2
2	Угтаалцайдам сумын дотуур байр угсарлтын ажил	-	-	1	-	-	1
3	Баянчандмань суманд 150 ортой цэцэрлэг шинээр барих ажил	-	-	1	-	1	-
4	Алтанбулаг суманд 13.7 км авто зам шинээр барих ажил	-	3	3	-	2	4
5	Зуунмод сумын жишиг хорооллыг эрчим хүчинд холбох ажил	-	-	1	-	-	1
6	Өндөрширээт суманд сургуулийн дотуур байр шинээ барих ажил	-	1	-	-	-	1
7	Лүн суманд 450 суудалтай спорт цогцолборын барилга шинээр барих ажил	-	1	-	-	1	-
8	Зуунмод сумын Нацагдорж багийн төвийн барилга угсралтын ажил	-	1	-	-	1	-
9	Цөлжилтийг бууруулах ажил 50.0га-д бэлчээрийн хортонтой тэмцэх	-	1	-	-	-	1
10	Цөлжилтийг буулах ажил үлийн цагаан огодотой тэмцэх	-	1	-	-	-	1
11	9 сумын ЭМТ-д лаорбаторийн то/тө худалдан авах	-	1	-	-	-	1
12	Заамар сумын 1-р сургуулийн дотуур байрны дээвэр, цахилгаан засвар	-	-	1	-	-	1 хүчингүй болгож дахин зарласан.
13	Батсүмбэр сумын ЕБС, СӨБ, ЭМТ-н хүнсний материал худалдан авах	-	-	1	-	1	-
Нийт дүн		1	9	12	-	9	13

Гарсан гомдлын шийдвэрлэлт:

- Төв аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвүүдийн эмнэлэгт эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх ТӨАОНӨГ/201901023 дугаартай 31 багцтай тендер шалгаруулалтын багц 14-т Мидклийн ХХК, багц 15-т Чоногол трэйд ХХК, багц 1, 2-т Моносфарм ХХК-иуд тус тус гомдол гаргасан байна. Сангийн яамнаас 2019.03.04-ны 6-1/1098 дугаар албан бичгээр тендер шалгаруулалтыг түр түдгэлзүүлж хянан үзэж 2019.03.15-ны өдрийн 6-1/1397 дугаар албан бичгээр багц 14, 15-т гарсан гомдол үндэслэлгүй буюу захиалагчийн шийдвэр үндэслэлтэй тул гэрээ байгуулах, багц 1, 2-т гарсан гомдлыг дахин хянан үзэж үнэлэх шийдвэр ирсэн тул дахин үнэлж багц 1, 2 тендерийн гэрээг Моносфарм ХХК-тай байгуулах шийдвэрийг хүргүүлж ажилласан.
- Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас эрх шилжүүлж тендер шалгаруулалтыг аймагт зохион явуулсан Төв, Угтаалцайдам сумын 100 ортой сургуулийн дотуур байрны барилга угсралтын ажлын БСШУСЯ/201902013 дугаартай ажилд “БЧГ” ХХК гомдол гаргаж дахин үнэлгээ хийхийг захиалагч байгууллагад ирүүлсний дагуу дахин үнэлгээ хийхэд гомдол гаргагч “БЧГ” ХХКомпаний санал болгосон инженер техникийн ажилчны мэргэжлийн диплом нь хуурамч байсан тул гомдол гаргагч “БЧГ” ХХКомпанид мэдэгдэж, тус компани тендерээсээ татгалзсан байна. Захиалагч гэрээг Тэнгэрийн долоон од ХХК-тай байгуулсан. Гэрээний дүн 1 505.3 сая төгрөг.
- Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас эрх шилжүүлж тендер шалгаруулалтыг аймагт зохион явуулсан Төв, Баянчандмань сумын 150 ортой цэцэрлэгийн барилга угсралтын ажлын БСШУСЯ/201902014 дугаартай ажилд “ЖуЖу” ХХК гомдол гаргаж үндэслэлгүй тул захиалагч гэрээг Төв цогт өлзийт ХХК-тай байгуулсан. Гэрээний дүн 998.3 сая төгрөг.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Зуунмод сумын жишиг хорооллыг эрчим хүчний нэгдсэн системд холбох ажилд Хустайн шил ХХК гомдол гаргаж Сангийн яамны 2019.05.14-ны өдрийн 6-1/3016 дугаар албан бичгээр гүйцэтгэгч сонгох ажиллагааг түр түдгэлзүүлэн шалгаж 2019.05.24-ны өдрийн 6-1/3358 дугаар албан бичгээр үнэлгээг дахин хийх

шийдвэрийг ирүүлсэн. Захиалагч дахин үнэлгээг хийж Хустайн шил ХХК-тай гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн.

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Зам, тээврийн яамнаас эрх шилжүүлсэн Алтанбулаг сумын төвийг төв замтай холбох 13 км авто замын ЗТХЯ/201901054 дугаартай ажлын тендерт 3 компани гомдол гаргаж Сангийн яамны 2019.06.04-ны өдрийн 6-1/3632 дугаар албан бичгээр гүйцэтгэгч сонгох ажиллагааг түр түдгэлзүүлж хянан үзэж хариуг 2019.06.19-ны 6-1/4164 дугаар албан бичгээр мэдэгдсэн. Тус тендерт Билэгт зам ХХК, Хурдны зам ХХК-ны гомдол үндэслэлгүй, захиалагчийн шийдвэр үндэслэлтэй, Арц суврага ХХК-ны гомдол үндэслэлтэй буюу захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон Ялгуусан ХХК-ний ерөнхий инженер нь ТББичгийн ТШӨХ-н ТООЗ-ны 5.3 (г)-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дахин нягтлах шаардлагатайг мэдэгдэж захиалагч байгууллага хянан үзэж байна.

1.7. Чанар стандартын шаардлага хангасан дотоодын бараа худалдан авсан мөнгөн дүн, нийлүүлэгчийн нэр, гэрээний хэрэгжилтийн байдал:

- Сумдын ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдсан дотоодын чанар стандарт хангасан бараа, худалдан авах ажилд тайлан оны жилийн эцэст 2,300.9 сая төгрөгийн мах, сүү, төмс, хүнсний ногоо, аарц, тараг, гурил, гурилан бүтээгдэхүүн, талх нарийн боов, өндөг, цэвэр ус зэрэг нэр төрлийн худалдан авалт хийгдсэн байна.

Хоёр. Худалдан авах ажиллагааны цахим системийг ашигласан талаар

2.1. Худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан тендер шалгаруулалт тоо, хувь болон систем ашиглалтын байдал:

Аймаг, сум болон төсөвт байгууллага, ОНӨААТҮГазруудад нийт 1238 төсөл, арга хэмжээг 70,272.3 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж, шат шатны Төсвийн захирагч, төсвийн шууд захирагч нарийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Төрийн худалдан авах ажиллагааны цахим www.tender.gov.mn системд бүртгэн оруулж аймгийн хэмжээнд 100 хувь цахимд шилжүүлж, цахим тендер зарлан ажиллаж байна.

2.2. Ерөнхий гэрээ байгуулах журмын дагуу цахим дэлгүүрийн ашиглалт болон тухайн худалдан авсан бараа, үйлчилгээний тоо, мөнгөн дүн, гэрээний хэрэгжилтийн байдал:

Аймгийн хэмжээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар аймгийн Эрүүл мэндийн газар 23 нэр төрлийн эм, 1 эмнэлгийн хэрэгсэл нийт 224,6 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй барааг ерөнхий гэрээний цахим дэлгүүрээс худалдан авч 159,9 сая төгрөгийн гэрээг 9 аж ахуйн нэгжтэй байгуулж ажилласан.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн өөрийн 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ерөнхий гэрээний журмаар худалдан авалт зохион байгуулагдаагүй.

Гурав. Харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны талаар:

3.1. Тухайн төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын тоо, тэдгээрийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн талаар ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагааг зааварчилгаа, аргачлалаар хангасан байдал болон түүнд хяналт тавьж ажилласан байдал:

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд 27 сумын ЗДТГазар, 12 агентлаг, 2 ОНӨААТҮГазрууд нийт 41 төсвийн шууд захирагчтай ажиллаж байгаагийн дээр аймгийн Орон нутгийн өмчийн газраас аймаг, сум, төсөвт байгууллагын түвшинд 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажилд тогтмол мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Үүнд:

-Сумдын худалдан авах ажиллагаа хариуцсан албан хаагчдад 2019 оны 1 сард 2 өдрийн сургалтыг, аймгийн төсвийн байгууллага, ОНӨААТҮГазар нийт 19 байгууллагын нягтлан бодогч нарт төрийн худалдан авах ажиллагааны цахим www.tender.gov.mn системийн сургалтыг зохион явуулж, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнахад анхаарах асуудлын талаар арга зүйн дэмжлэг үзүүлж цахим системд захиалагч байгууллагаар бүртгүүлэн ХАА-ны төлөвлөгөөг системд байршуулж нийтэд ил, тод болгож ажилласан.

2019 онд агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газарт төлөвлөгдсөн төсөл, арга хэмжээ: /нийт төсөвт өртөг, төсөл, арга хэмжээний тоо/

Он	Нэр	Төсөл, арга хэмжээний тоо	Батлагдсан санхүүжилт /сая,төг/
2019	Агентлагийн түвшинд	218	6,213.7
	Сумдын түвшинд	924	20,052.3

Агентлагийн түвшинд зохион явуулсан ХАА-ны тендер шалгаруулалтын журам, арга:

д/д	Тендер зохион байгуулсан арга	Ажлын тоо
ХАА-г зохион байгуулах ажлын хувьд		
1	Нээлттэй тендер шалгаруулалт	3
2	Хязгаарлагдмал тендер шалгаруулалт	-
3	ТШОЖ-харьцуулалтын арга	17
4	Зөвлөх үйлчилгээ	-
5	Гэрээ шууд байгуулсан	-
Бүлгийн дүн		20
ХАА зохион байгуулахгүй ажлын хувьд		
1	ШХА-шууд худалдан авах	198
2	ШС-шууд санхүүжилт олгох	
Бүлгийн дүн		198
НИЙТ ДҮН		218

Сумдын түвшинд зохион явуулсан ХАА-ны тендер шалгаруулалтын журам, арга:

д/д	Тендер зохион байгуулсан арга	Ажлын тоо
ХАА-г зохион байгуулах ажлын хувьд		
1	Нээлттэй тендер шалгаруулалт	50
2	Хязгаарлагдмал тендер шалгаруулалт	1
3	ТШОЖ-харьцуулалтын арга	190
4	Зөвлөх үйлчилгээ	3
5	Олон нийтийн оролцоотой ХАА	1
6	Гэрээ шууд байгуулсан	151
Бүлгийн дүн		396
ХАА зохион байгуулахгүй ажлын хувьд		
1	ШХА-шууд худалдан авах	528
2	ШС-шууд санхүүжилт олгох	
Бүлгийн дүн		528
НИЙТ ДҮН		924

3.2. Төсвийн Ерөнхийлөн захирагч өөрийн харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ өгсөн дотоод аудитын зөвлөмж, дүгнэлт болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Төсвийн ерөнхийлөн захирагчын 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан улс, аймгийн хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилтэд Төв аймаг дахь Төрийн аудитын газар хяналт шалгалт хийж ажилласан байгаа бөгөөд жилийн эцсийн дүгнэлт гарах хугацаа болоогүй буюу хуулийн хугацаанд хяналт шалгалт хийгдэж байна.

Дөрөв. Худалдан авах ажиллагааны талаарх дүгнэлт, санал:

4.1. Төсвийн Ерөнхийлөн захирагч тухайн жилийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн үр дүнгийн талаарх өөрийн үнэлгээ, дүгнэлт:


Аймагт хэрэгжсэн нийт худалдан авах ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр:

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 89 төсөл, хөтөлбөрөөс тендер шалгаруулалт зохион байгуулах 73 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын явц жилийн эцсийн байдлаар 99 хувьтай байна.

4.2. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байдал:

Аймгийн Засаг даргын 2018 оны А/736, А/391, А/644 дүгээр захирамжаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэлд хяналт тавих үүрэг бүхий захиалагчаар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар, аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГазруудыг томилж гэрээний гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж ажиллуулж байна.


(Төв аймгийн Баянчандмань суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 150 ортой цэцэрлэгийн барилга угсралтын ажил. Гүйцэтгэгч: Төв Цогт Өлзийт ХХК гэрээний дүн 998.3 сая төгрөг)



**(Төв аймгийн Өндөрширээт суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 100 ортой сургуулийн дотуур байрны барилга угсралтын ажил.
Гүйцэтгэгч: Арбулаг ХХКомпани гэрээний дүн 1,129.2 сая төгрөг)**



**(Төв аймгийн Лүн суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 450 суудалтай спорт цогцолборын барилга угсралтын ажил.
Гүйцэтгэгч: Өгөөмөр Уул ХХКомпани гэрээний дүн 1,069.5 сая төгрөг)**



**(Төв аймгийн Дэлгэрхаан сумын сургуулийн барилгын дээвэр, гадна фасадны засварыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар засварлав.
Гүйцэтгэгч: Дөрвөн Лхагва ХХКомпани гэрээний дүн 115.0 сая төгрөг)**



(Төв аймгийн Мөнгөнморьт сумын цэцэрлэгийн барилгын дээвэр, гадна фасадны засварыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар засварлав. Гүйцэтгэгч: Вистагрупп ХХКомпани гэрээний дүн 53.2 сая төгрөг)



4.3. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг цаашид улам үр дүнтэй болгох санал, зөвлөмж, хүсэлт:

Төлөвлөлт:

-Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн дагуу цахим тендер шалгаруулалт явуулахад эрх шилжүүлсэн ТЕЗ, бодлогын газрууд системээр шилжүүлэх эрхийг шийдвэр гарсан даруй шилжүүлж ажиллах.

Хэрэгжилт:

-Худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад төрийн байгууллагуудаас гардаг тодорхойлолт лавлагаа мэдээллийг авах нэгдсэн зохицуулалтаар тендерт оролцогчдоос шаардахгүй байх цахим худалдан авах ажиллагааны цахим системийг өргөжүүлэх шаардлагатай.

-тендер шалгаруулалтын үнэлгээг хүний оролцоогүйгээр цахимаар 100 хувь хийдэг болгох.

-Үнэлгээний хорооны гишүүдийн шийдвэр гаргалтанд анхаарч алдаатай буруу шийдвэр гаргасан гишүүдийн АЗ гэрчилгээг хүчингүй болгох, арга хэмжээ авч хариуцлага тооцдог болох.

Тайлагналт:

-Монгол Улсын Сангийн сайдаас 2019 оны худалдан авах ажиллагааны тайланг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр тайлагнах чиглэл өгөгдсөний дагуу тайланг цахим www.tender.gov.mn системд үүсгэсэн боловч тайлагнах цэсний мэдээлэл татагдалт зөрүүтэй байсан тул Сангийн яамны холбогдох албан тушаалтан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэдээлэл технологийн албанд албан ёсоор мэдэгдсэн бөгөөд тодорхой хариу ирээгүй тул тайланг цаасан суурьтайгаар Сангийн сайдын 2018 оны 281

дүгээр тушаалаар батлагдсан тайлагнах маягтуудаар тайлагнав. Цаашид цахим системийн тайлагнах цэсийг бүрэн ашиглах, тайлан үнэн зөв татагддаг болгох ингэснээр мэдээллийн зөрүүтэй байдал үүсэхээс сэргийлэх төдийгүй давхцсан ажил гүйцэтгэх байдал арилах юм.

ТӨВ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2019 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
(ТАЙЛАНТ ХУГАЦАА: 2019 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЫ ӨДРИЙН БАЙДЛААР)
АЙМГИЙН ИТХ-ЫН 2019 ОНЫ 13-Р ХУРЛЫН 02-Р ТОГТООЛООР НЭМЭГДСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ НЭМЖ ТУСГАСАН

№	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал, багцлалт	Төрөл	Батлагдсан төсөвт өртөг (мян.төг)	2019 онд санхүүжих дүн (мян.төг)	Эрх шилжүүлсэн эсэх /ТЕЗ-н нэр/ шийдвэрийн дугаар, огноо	Аймгийн Засаг даргын шийдвэрээр томилогдсон захиалагч байгууллага	Гэрээний дүн (мян.төг)	Тендерийн хэмнэлт	Гүйцэтгэгчийн нэр, гэрээний дугаар	ХАА-нд мөрдсөн журам	Худалдан авах ажиллагаанд мөрдсөн хугацаа					Цахим эсэх	Тайлбар, тодруулга
											Үнэлгээний хороо байгуулсан огноо	tender.gov.mn-д урилга нийтэлсэн огноо	Гэрээ байгуулах эрх олгосон огноо	tender.gov.mn-д дүн нийтэлсэн огноо	Гэрээ дуусгаж дүгнэсэн огноо		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14				
УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ																	
1	Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны Туул тосгоны хатуу хучилттай авто замын төгсгөлөөс Төв аймгийн Алтанбулаг сумын төв хүртэлх хатуу хучилттай авто зам, 13.7 км /Төв, Алтанбулаг сум/	Ажил	13,039,900,000	6,500,000,000	МУЗГ-ын 2018 оны 388-р тогтоол		10,506,041,326	2,533,858,674	Ялгуусан ХХК	НТШ	2019.02.04	2019.02.18, 2019.04.01	2019.05.24, 2019.07.04	2019.07.19	он дамжих ажил: 2019.07.26-2020.06.15	цахим	Гэрээ байгуулсан.
2	Шавартайн голын төмөр бетон гүүрийн их засвар, шинэчлэлт, 39.8 у/м /Төв, Борнуур сум/	Ажил	1,447,100,000	1,447,100,000			1,378,984,143	68,115,857	"33Б" ХХК	НТШ	2019.02.04	2019.02.15	2019.03.26	2019.05.28	2019.05.01-2019.10.31	цахим	Гэрээ байгуулсан.
3	Сумын төвийн авто зам, 3.2 км /Төв, Эрдэнэсант сум/	Ажил	550,000,000	550,000,000			550,000,000	-	Төв АЗЗА ТӨХК	НТШ	2019.05.06	2019.05.10, 2019.06.11	2019.07.19, 2019.09.05	2019.07.19	2019.09.05-2019.11.15	цахим	Тендерийн нээлтийг 2019.06.10-нд нээсэн. Оролцогч оролцоогүй тул дахин НТШ зарласан. Нээлтийг 2019.07.16-нд хийсэн оролцогчгүй тул захиалагч БЗОСК-д гэрээ шууд байгуулах дүгнэлт өгсөн. Захиалагч Төв АЗЗА ТӨХК-тай гэрээ байгуулсан.
4	Багийн төвийн барилга /Төв, Зуунмод сум, Баянхошуу баг/	Ажил	350,000,000	350,000,000	ЗГХЭГ-н 2019.01.10-ны 05 дугаар тушаал		285,996,333	64,003,667	Вистагрупп ХХК	НТШ	2019.04.24	2019.05.06	2019.07.16	2019.07.30	2019.08.01-2019.12.30	цахим	Гэрээ байгуулсан.
5	Багийн төвийн барилга /Төв, Зуунмод сум, Нацагдорж баг/	Ажил	350,000,000	350,000,000			318,482,083	31,517,917	Тусгал төв ХХК	НТШ	2019.04.24	2019.05.06, 2019.07.17		2019.09.12	2019.09.13-2019.12.25	цахим	Тендерийн нээлтийг 2019.06.19 хийсэн. ҮХороо дахин НТШ-г зарлахаар шийдвэрлэсэн. Дахин зарласан. Нээлтийг: 2019.08.16-нд хийсэн ҮХорооны шийдвэрээр захиалагчид гэрээ шууд байгуулах дүгнэлт хүргүүлсэн. Тусгал төв ХХК-тай гэрээ байгуулсан.
6	Сумын эрүүл мэндийн төвийн засвар /Төв, Дэлгэрхаан сум/	Ажил	50,000,000	50,000,000	ЭМСайдын 2019 оны А/58 дугаар тушаал	Аймгийн Барилга орон сууц корпораци ОНӨААТҮГ	45,229,709	4,770,291	Өндөрлөг ХХК	ХА	2019.03.29	2019.05.14	2019.06.10	2019.08.26	2019.07.01-2019.08.20, нэмэлт гэрээ 2019.10.02-2019.10.15	цахим	Гэрээ байгуулсан.
7	Дотуур байрны барилга /Төв, Угтаалцайдам сум/	Ажил	1,800,000,000	1,000,000,000			1,505,607,870	294,392,130	Тэнгэрийн долоон од ХХК	НТШ	2019.03.01	2019.03.15	2019.04.26	2019.06.04	он дамжих ажил: 2019.06.07-2020.08.20	цахим	Гэрээ байгуулсан.

8	Дотуур байрны барилга /Төв, Өндөрширээт сум/	Ажил	1,300,000,000	1,300,000,000	БСШУССайд 2019 оны А/69 дугаар тушаал	1,129,222,039	170,777,961	Ар булаг ХХК	НТШ	2019.03.22	2019.04.01	2019.06.10	2019.07.01	2019.06.25- 2019.12.30	цахим	Гэрээ байгуулсан.
9	Спортын төрөлжсөн сургуулийн барилга, 640 суудал /Төв, Зуунмод сум/	Ажил	3,978,400,000	2,000,000,000		4,885,204,620		Эл Си Би ХХК	НТШ	2019.04.24	2019.05.06, 2019.07.04	2019.08.08	2019.09.09	он дамжих ажил: 2019.08.20- 2020.12.25	цахим	Гэрээ байгуулсан.
10	Сургуулийн барилга /Төв, Цээл сум/	Ажил	1,200,000,000	1,200,000,000		1,067,997,865	132,002,135	Мандалт констракшн ХХК	НТШ	2019.04.11	2019.04.24	2019.06.10	2019.07.01	2019.06.24- 2019.12.25	цахим	Гэрээ байгуулсан.
11	Сургуулийн барилга 920 суудал /Төв, Батсүмбэр сум/	Ажил	4,907,800,000	1,100,000,000		8,312,984,296		Клаймакс- Интернэшнл ХХК, Баяндөрвөлж ХХК түншлэл	НТШ	2019.05.21	2019.08.02	2019.09.07	2019.09.24	он дамжих ажил: 2019.09.20- 2020.12.25	цахим	Гэрээ байгуулсан.
12	Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Төв, Жаргалант сум/	Ажил	1,100,000,000	1,100,000,000		1,048,542,145	51,457,855	Их даян бүүвэй ХХК	НТШ	2019.04.11	2019.05.06	2019.06.12	2019.06.17	2019.06.24- 2019.12.30	цахим	Гэрээ байгуулсан.
13	Цэцэрлэгийн барилга 100 ор, /Төв, Баянчандмань сум/	Ажил	1,100,000,000	1,100,000,000		998,373,350	101,626,650	Төв цогт өлзийт ХХК	НТШ	2019.03.01	2019.03.11	2019.04.26	2019.05.14	2019.05.31- 2019.11.25	цахим	Гэрээ байгуулсан.
14	Сургуулийн барилгын их засвар /Төв, Сэргэлэн сум/	Ажил	300,000,000	300,000,000		269,456,481	30,543,519	Голден прогресс ХХК	НТШ	2019.04.22	2019.04.24	2019.06.06	2019.06.17	2019.06.20- 2019.08.20, нэмэлт гэрээ 2019.09.24- 2019.10.08	цахим	Гэрээ байгуулсан.
15	Соёлын төвийн барилгын их засвар /Төв, Баянхангай сум/	Ажил	100,000,000	100,000,000		95,000,000	5,000,000	Харшийн цуурай ХХК	НТШ	2019.04.22	2019.04.24	2019.06.06	2019.06.17	2019.06.17- 2019.08.25	цахим	Гэрээ байгуулсан.
16	Спорт цогцолборын барилга, 450 суудал /Төв, Лүн сум/	Ажил	1,199,000,000	1,199,000,000	1,069,502,654	129,497,346	Өгөөмөр Уул ХХК	НТШ	2019.03.22	2019.04.01	2019.05.24	2019.06.03	2019.06.17- 2019.12.25	цахим	Гэрээ байгуулсан.	
ДҮН			32,772,200,000	19,646,100,000	33,466,624,914	3,617,564,002										

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

1. ШИЛЖИХ БАРИЛГА

1.1	100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын үлдэгдэл санхүүжилт /Төв, Сүмбэр сум/	Ажил	536,401,100	336,401,100	Аймгийн Барилга орон сууц корпораци ОНӨААТҮГ	336,401,100		Их даян бүүвэй ХХК	НТШ	2018 онд тендер шалгаруулалтыг зохион байгуулсан. Ажлын явц 100 хувьтай ашиглалтад бүрэн орсон. Батлагдсан хөрөнгө санхүүжилт байдлаар олгогдоно.					цахим	хэрэгжилт 100%
1.2	Багийн төвийн жишиг барилга барих ажлын үлдэгдэл /Төв, Батсүмбэр сум/	Ажил	58,501,300	39,501,300		39,501,300		Өгөөмөр Уул ХХК	ХА	2018 онд тендер шалгаруулалтыг зохион байгуулсан. Ажлын явц 100 хувьтай ашиглалтад бүрэн орсон. Батлагдсан хөрөнгө санхүүжилт байдлаар олгогдоно.					цахим	хэрэгжилт 100%
БҮЛГИЙН ДҮН			594,902,400	375,902,400		375,902,400										

2. ШИНЭЭР ЭХЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2.1	Нийтийн эзэмшлийн 23, 26-р байрнуудын гадна фасад, дээврийн их засварын ажил /Төв, Зуунмод/	Ажил	210,000,000	210,000,000	Аймгийн Барилга орон сууц корпораци ОНӨААТҮГ	194,313,359	15,686,641	Цац орхон ХХК	НТШ	2019.03.04	2019.03.11	2019.04.22	2019.05.23	2019.07.08	цахим	Гэрээ байгуулсан.
2.2	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, дээврийн их засвар /Төв, Баян-Өнжүүл сум/	Ажил	180,000,000	180,000,000		79,577,245	100,422,755	Шинэчлэл-Инвест ХХК	НТШ	2019.09.05	2019.09.16	2019.09.25	2019.10.03	2019.11.25	цахим	Гэрээ байгуулсан.
2.3	Цэцэрлэгийн барилгын дээврийн их засвар /Төв, Мөнгөнморьт сум/	Ажил	60,000,000	60,000,000		53,205,385	6,794,615	Вистарупп ХХК	ХА	2019.03.01	2019.02.27	2019.04.04	2019.05.22	2019.07.10	цахим	Гэрээ байгуулсан.
2.4	Ерөнхий боловсролын сургуулийн барилгын дээвэр, фасадны их засвар /Төв, Эрдэнэсант сум/	Ажил	80,000,000	80,000,000		71,614,887	8,385,113	Дөрвөн Лхагва ХХК	ХА	2019.02.20	2019.02.27	2019.03.26	2019.04.01	2019.06.14	цахим	Гэрээ байгуулсан.
2.5	Дунд сургуулийн дээврийн их засвар /Төв, Дэлгэрхаан сум/	Ажил	120,000,000	120,000,000		115,062,069	4,937,931	Дөрвөн Лхагва ХХК	НТШ	2019.03.29	2019.04.01	2019.05.23	2019.05.28	2019.07.10	цахим	Гэрээ байгуулсан.

2.6	Цэцэрлэгийн дээврийн их засвар /Төв, Зуунмод сум, Бүжинхэн А байр/	Ажил	95,000,000	80,000,000			90,349,770	4,650,230	Төв цогт өлзийт ХХК	НТШ	2019.02.20	2019.02.26	2019.04.16	2019.05.23	2019.06.25	цахим	Гэрээ байгуулсан.				
2.7	Дотуур байрны их засвар /Төв, Сүмбэр сум/	Ажил	418,800,000	80,000,000			66,201,763	13,798,237	Жу Жу ХХК	НТШ	2019.02.20	2019.02.27	2019.04.16	2019.04.22	2019.06.20	цахим	Гэрээ байгуулсан.				
2.8	Нийтийн эзэмшлийн байрнуудын орц засварын оролцоо (9 байрны 24 орц) /Төв, Зуунмод сум/	Ажил	45,600,000	45,600,000		Зуунмод сумын ЗДТГ	41,002,610	4,597,390	Өндөрлөг ХХК	ХА	2019.01.29	2019.05.17	2019.07.16	2019.07.16	2019.08.25, захиалагч сунгасан 2019.10.25	цахим	Гэрээ байгуулсан.				
2.9	Инженерийн хийцтэй худаг шинээр гаргах 26 сум	Ажил	312,000,000	312,000,000		Аймгийн ХХААГазар, БЗОСК	100,684,053	24,885,437	Багц 1-т Ус инженеринг ХХК	НТШ	2019.01.29	2019.02.13, 2019.04.02	2019.08.12			2019.10.01	цахим	Багц 1-т НТШ-г 2 удаа зохион байгуулсан. ҮХорооны шийдвэрээр захиалагч гэрээ шууд байгуулсан.			
							99,222,030		Багц 2-т Ус инженеринг ХХК			2019.02.13						2019.04.01	2019.04.02	2019.08.01	Гэрээ байгуулсан.
							87,208,480		Багц 3-т Усны барилга ХХК			2019.04.01						2019.04.02	2019.08.01	Гэрээ байгуулсан.	
2.10	Жишиг хорооллыг эрчим хүчний нэгдсэн системд холбох ажил /Төв, Зуунмод сум/	Ажил	256,386,900	149,753,600		Аймгийн Барилга орон сууц корпораци ОНӨААТҮГ	114,895,667	34,857,933	Хустайн шил ХХК	НТШ	2019.02.20	2019.02.26	2019.06.16	2019.10.11	2019.11.25	цахим	Захиалагч дахин зарлах хүсэлт гаргасан. ҮХороо 2019.09.24-нд хуралдаж дахин тендер зарлах үндэслэлгүй гэж үзэж татгалзаж 4-р хурлын шийдвэрээ баталгаажуулсан. Гэрээ байгуулагдсан				
2.11	Гэр хорооллыг дулаан, цэвэр усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбох /Төв, Зуунмод сум 2, 5-р баг/	Ажил	1,267,056,500	203,800,000			199,032,699	4,767,301	Мөнхтермо ХХК	НТШ	2019.05.24	2019.06.03	2019.07.24	2019.08.02	2019.10.01	цахим	Гэрээ байгуулсан.				
2.12	Соёлын төвийн зөөврийн тайз, үзэгчдийн сандал /Төв, Баянцогт сум/	Бараа	50,000,000	50,000,000		Баянцогт сумын ЗДТГ	47,921,198	2,078,802	Хабул интернэшнл ХХК	ХА	2019.02.20	2019.02.27	2019.03.26	2019.07.01	2019.05.25	цахим	Гэрээ байгуулсан.				
2.13	Дотуур байрыг ариун цэврийн байгууламжтай болгох орон нутгийн оролцоо /Төв, Борнуур сум/	Ажил	45,000,000	45,000,000		Аймгийн Барилга орон сууц корпораци ОНӨААТҮГ	45,000,000	-	Роял кинг констракшн ХХК	ГШБ	Захиалагч байгууллага өөрсдөө гэрээ шууд байгуулж ажилласан.					цахим	Захиалагч БЗОСК-д 2019.07.29-ны 242, 2019.09.18-ны 268 дугаар албан бичгээр хариу ирүүлэхийг хүссэн. 2019.10.18-ны байдлаар хариу ирээгүй				
2.14	Сургууль ариун цэврийн байгууламжтай болгох орон нутгийн оролцоо /Төв, Баянцагаан сум/	Ажил	51,500,000	51,500,000			51,500,000	-	Роял кинг констракшн ХХК	ГШБ	Захиалагч байгууллага өөрсдөө гэрээ шууд байгуулж ажилласан.					цахим					
2.15	Сургууль ариун цэврийн байгууламжтай болгох орон нутгийн оролцоо /Төв, Баян сум/	Ажил	60,000,000	60,000,000			60,000,000	-	Роял кинг констракшн ХХК	ГШБ	Захиалагч байгууллага өөрсдөө гэрээ шууд байгуулж ажилласан.					цахим					
2.16	Баруун Зуунмод багийн гэр хорооллын айлуудад дулааны салбар шугам татах	Ажил	24,799,000	21,000,000			19,535,150		Төв Чандмань ОНӨААТҮГ	ХА	2018 онд тендер шалгаруулалтыг зохион байгуулсан. Ажлын явц 100 хувьтай ашиглалтад бүрэн орсон. Батлагдсан хөрөнгө санхүүжилт байдлаар олгогдоно.					цахим		хэрэгжилт 100%			
БҮЛГИЙН ДҮН			3,276,142,400	1,748,653,600			1,536,326,365	225,862,385													
2019 ОНД НЭМЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ																					
2.17	Дулааны станцын 2-р хэлхээний гадна шугам, сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажлын зураг, төсөв	Зөвлөх	23,400,000	23,400,000			23,400,000		ДНТ ХХК	БУА	2019.02.26	2019.03.04	2019.04.26		2018.08.05		Захиалагч нь БЗОСК ОНӨААТҮГ захиалагч тендер зарласан. Гэрээний нийт дүн 149.7 сая төгрөг 2019 онд 23.4 сая төгрөгийг олгож байгаа.				
БҮЛГИЙН ДҮН			23,400,000	23,400,000			23,400,000	-													
3. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ																					

